



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/19

Цагаан-Уул сум

Г Үнэлгээний хороо байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлаар хийгдэх сумын төвийн камержуулалт нэмэгдүүлэх ажлын техникийн тодорхойлолт боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ахлагч: У.Аварзэд (Засаг даргын орлогч)

Гишүүд: Б.Ичинхорлоо (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: А.Хишигбаяр (Төрийн сангийн мэргэжилтэн)

2. Ажлын даалгавар боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, захиалагчид танилцуулж ажиллахыг үнэлгээний хорооны ахлагч (У.Аварзэд)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-т даалгасугай.



ДАРГА

С.ГОНЧИГНЯМ